



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/39

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2023 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэвшийн говь” ХХК-ийн халаалтын үйл ажиллагаа доголдож эрсдэлтэй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан тус компанийн халаалтын үйл ажиллагааг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-т шилжүүлж түр хариуцуулан ажиллуулсугай.

2. Дулаанаар хангах ажиллагааг шилжүүлэх хүртэл хугацаанд халаалтын үйл ажиллагааг хэвийн явуулахыг “Тэвшийн говь” ХХК-ийн ерөнхий захирал (Н.Бадрах)-д үүрэг болгосугай.

3. Дулаанаар хангах ажиллагааг шилжүүлэн авч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг халаалт, дулаанаар хэвийн хангаж ажиллахыг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын захирал (О.Бархүү)-д үүрэг болгосугай.

4. Дулаанаар хангах ажиллагааг шилжүүлсэнтэй холбогдуулан ажилчдын цалин хөлсийг бууруулахгүйгээр шилжүүлэн авч ажиллуулахыг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-ын захирал (О.Бархүү)-д, холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван)-д тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

4823110 10